

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин түүний гүйцэтгэл.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	14
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5. Зорилтот түвшин түүний гүйцэтгэл.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.09 № 06/746
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

“ХИЛИЙН 0288 ДУГААР АНГИ”
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАГЧ, ХУРАНДАА
Б.БАТБАЯР ТАНАА

Үүрэг, хариуцлага

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.Наранчимэг Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг “Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын захирагч, хурандаа Б.Батбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цаашид мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, үргүй зардал гаргахгүй байх, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журам зааврыг мөрдөж ажиллах, бүртгэл тайлагналыг сайжруулах, байгууллагын дотоод хяналтын системийг сайжруулах талаар Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн өмчит байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын удирдлага тайланг хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан Сангийн сайдын журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян суварга Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ 2019 оны санхүүгийн тайланг “Баян суварга Аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Н/04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Тус анги 2019 онд “Бүтээгдэхүүний чанар, үйлчилгээний стандартыг дээшлүүлж, ажилтан алба хаагчдын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант онд Хил хамгаалах байгууллагын цэргийн алба хаагчдын дүрэмт болон тусгай зориулалтын 69 нэр төрлийн 4,279.0 сая төгрөгийн хувцас, хэрэглэлд гэрээ байгуулан, үлгэр, стандарт загварын дагуу үйлдвэрлэн захиалагчдад нийлүүлсэн байна.

Дэвшилтэт техник, технологийг үйлдвэрт нэвтрүүлэн туузан хутгатай эсгүүрийн машин, малгайн хүрээ оёх хөндлөн тулгуурт оёдлын машин, нүх гаргаж хэрэх машин, нүх гаргаж цоологч машин зэрэг тоног төхөөрөмжийг худалдан авч, ашигласнаар үйлдвэрлэлийн бүтээмжийг 10-12 хувиар нэмэгдүүлсэн. Мөн Оёдлын үйлдвэрийн нэгж бүтээгдэхүүний ажлын хөлсийг ажилбараас нь шалтгаалан 13.1 хувиар өсгөж, үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт гар дамжин шалгах журам нэвтрүүлж, ажлын хариуцлагыг нэмэгдүүлснээр бүтээгдэхүүний чанарын түвшин 20 хувиар дээшилсэн байна.

Хил хамгаалах ерөнхий газраас МУИС-ийн Бизнесийн сургууль, Бизнес төвөөр “Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын 2017-2021 онд хэрэгжүүлэх “Бизнес төлөвлөгөөг” хийлгэсэн бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Оёдлын үйлдвэрлэл,
- Газар тариалан,
- Аварга тосон амралтын үйлчилгээ,
- Хэвлэх цех,
- Дүрэмт хувцасны дэлгүүр,
- Орон сууц ашиглалтын үйл ажиллагаа.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус ангийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл дунд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ санхүүгийн Ритус ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн “Ноён” програм хангамж ашигладаг байна.

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 18 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,908.7 сая төгрөгөөс тооцон 118.2 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны суурь үзүүлэлтийн дүнгээс матариаллаг байдлын түвшинг тооцон 108.3 сая төгрөгөөр тогтоолоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 96,060.8 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	197.3	13.7	(183.5)
Авлага	333.0	360.7	27.7
Бараа материал	967.6	1,062.6	94.9
Үндсэн хөрөнгө	1,766.1	1,730.9	(35.2)
Нийт хөрөнгө	3,264.0	3,167.9	(96.1)
Өр төлбөр	269.2	110.8	(158.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,994.8	3,057.1	62.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,264.0	3,167.9	(96.1)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 183.5 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны эцэст ХЗДХЯ-наас урьдчилж төлсөн 161.2 сая төгрөгийн орлогыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлага тайлант хугацааны эцэст 360.7 сая төгрөг болж, 8.3 хувь буюу 27.7 сая төгрөгөөр өссөн нь ХХЕГ-ын шийдвэрээр гэрээ хийгдээгүй хувцас үйлдвэрлэж нийлүүлсэн,

мөн тайлант оны эцэст хилийн ангиудад хүнсний ногоо, гэрээт цэргийн хувцас нийлүүлсэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд хилийн ангиудад нийлүүлсэн хувцас, хэрэглэлийн авлага 342.5 сая төгрөг, орон сууцны хэрэглэлээний төлбөр 18.1 сая төгрөг, Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 0.1 сая төгрөг тус тус байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 10.5 хувь буюу 94.9 сая төгрөгөөр өссөн нь дуусаагүй үйлдвэрлэл 46.4 сая төгрөг, үйлдвэрлэлийн болон хангамжийн материал 48.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дүн өмнөх оноос 35.2 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгийн дахин үнэлгээний хасагдуулга, үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн өсөлт зэрэгтэй холбоотой байна.

Өр төлбөр тайлант оны эцэст 110.8 сая төгрөг болж, өмнөх оноос 158.4 сая төгрөгөөр буурсан нь урьдчилж орсон орлогын 161.2 сая төгрөгийг тайлант онд төлж барагдуулсан, бэлтгэн нийлүүлэгчид өгөх өглөг 22.5 сая төгрөг, ААНОАТ-ын өглөг 14.8 сая төгрөг, НӨАТ-ын өглөг 19.3 сая төгрөг, бусад өглөг 0.6 сая төгрөгийг барагдуулсан байна.

Оны эцэст 60.0 сая төгрөгийн богино хугацаат зээлийн өглөг үүссэн байна. Өглөгийн үлдэгдэлд орон сууцны цахилгааны барьцааны өглөг 1.4 сая төгрөг, бусад байгууллагад өгөх өглөг 60.2 сая төгрөг, татварт өгөх өглөг 49.2 сая төгрөг тус тус байна.

2.9. Зорилтот түвшин түүний гүйцэтгэл

ХХЕГ-аас “Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд борлуулалтын орлогыг 4,893.8 сая төгрөг, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 4,252.8 сая төгрөг, удирдлагын зардлыг 415.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны ашгийг 203.4 сая төгрөг байхаар тус тус баталсан байна.

Тус анги 2019 онд оёдлын үйлдвэрлэлээс 4,489.3 сая төгрөг, газар тариалангаас 62.5 сая төгрөг, Аврага тосон дахь “Хилчин” амралтын газраас 60.3 сая төгрөг, дэлгүүрийн орлого 33.3 сая төгрөг, хэвлэх цехээс 104.5 сая төгрөг, орон сууц ашиглалтаас 387.1 сая төгрөг, тусгай хэрэгслэл бэлтгэхэд 252.7 сая нийт 5,389.7 сая төгрөгийн борлуулалтын, хүүгийн орлого 7.9 сая төгрөг, бусад 19.7 сая төгрөгийн орлого буюу нийт 5,417.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Нийт орлогоос борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 4,630.6 сая төгрөг, удирдлагын зардалд 607.0 сая төгрөг, санхүүгийн зардалд 2.6 сая төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардалд 150.7 сая төгрөг, бусад зардалд 25.8 сая төгрөг, нийт 5,416.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд Баянзүрх дүүргийн 72 дугаар хотхоны орон сууцны цахилгаан, ус, дулааны ашиглалтын ажиллагааг мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөхөд комиссоос шаардсан засвар үйлчилгээг хийхэд 155.4 сая төгрөг, ХХЕГ-тай байгуулсан өмнөх оны үр дүнгийн гэрээний урамшууллын 39.9 сая төгрөг зэрэг 195,3 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй зардлууд нь тус ангийн үйл ажиллагаанаас шалтгаалахгүйгээр гарч ерөнхий ба удирдлагын зардал хэтрэхэд нөлөөлсөн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 18 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 114.2 сая төгрөгний алдаа, зөрчил илэрснээс, 62.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 51.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 51.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авлага, өр төлбөр, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 5 төрлийн 145 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 акт тогтоож, 3 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийн дүн 51.3 сая төгрөг нь бидний тооцсон материаллаг байдлын түвшин 108.3 сая төгрөгөөс бага байгааг үндэслэн зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, стандартын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Тус анги 2019 онд кассаас 11.0 сая төгрөгийг бэлэн мөнгөөр шатахууны зардалд олгож, “Магнай трейд” ХХК-иас худалдан авсан 22.5 сая төгрөгийн шатахууны талоныг кассаар дамжуулан зарцуулсан боловч кассын гүйлгээний журналд талоны зарцуулалтыг тусд нь бүртгэж тайлагнаагүйгээс шатахууны зардалд тухай бүр талоноор эсвэл мөнгөөр олгож байгааг хянах, тооцох боломжгүй болсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 -д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “... анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Мөнгөн хөрөнгийн тайлан тооцоонд тавих дотоод хяналт суларч, холбогдох хууль эрхийн акт зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Цаашид кассаас олгож байгаа шатахууны зардлыг бэлэн мөнгөөр, талоноор гэж тусад нь ангилан бүртгэж, бэлэн мөнгө, үнэт цаасны тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Тус ангийн автомашины шатахуун зарцуулалтын тооцоог шалгаж үзэхэд Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Жолоочийн тооцооны хуудас НХМаягт Т-4 маягтыг хөтлөөгүй, 28.8 сая төгрөгийн шатахууны зарцуулалт, хэтрэлт, хэмнэлтийн тооцоог хийгээгүй, нормоор тооцож шууд зардал болгож тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх,

санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл: Хөрөнгийг үргүй зарцуулах, хууль эрхийн акт зөрчигдөх.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудас НХМаягт Т-4 маягыг хөтлүүлж, тухайн сард явсан километрийг үндэслэн шатахууны зарцуулалтын тооцоог бодож баталгаажуулан нягтлан бодох бүртгэлд тусгах. Улмаар шатахууны тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Зорилтот түвшний төлөвлөлттэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт: Тайлант оны зорилтот түвшний орлого, зардлын төлөвлөлтөөнд үндсэн бус үйл ажиллагааны орлого, зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлыг төлөвлөж өгөөгүй, Баянзүрх дүүргийн 72 дугаар хотхоны орон сууцны цахилгаан, ус, дулааны ашиглалтын ажиллагааг мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөхөд комиссоос шаардсан засвар үйлчилгээг хийхэд 155.4 сая төгрөг, ХХЕГ-тай байгуулсан өмнөх оны үр дүнгийн гэрээний урамшууллын 39.9 сая төгрөг зэрэг 195,3 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй зардлууд нь тус ангийн үйл ажиллагаанаас шалтгаалахгүйгээр гарч ерөнхий ба удирдлагын зардал хэтрэхэд нөлөөлсөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 21.1 дүгээр зүйлийн 21.1.2-д “Зорилтын саналд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон байгууллагын хэтийн зорилт, үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ, санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг, . . . зэрэг зүйлийг тусгана”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл: Байгууллагын төлбөрийн чадвар, эдийн засгийн үр ашигт сөргөөр нөлөөлөх, авлага, өр төлбөр ихсэх, орлого, зардлын гүйцэтгэлд тавих хяналт сулрах.

3.3.3 Өгсөн зөвлөмж: Орлого, зардлын төлөвлөгөөг тухайн жилийн үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөр, арга хэмжээтэй уялдуулан үндэслэлтэй зөв төлөвлөж, төлөвлөгөөний биелэлтэд тавих хяналтыг сайжруулахаар Албан шаардлага өгөх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаа

3.4.1 Илрүүлэлт: Тус анги санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа 2014 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг /НБББББ/-ийг баримтлан ажиллаж байна. Гэвч уг баримт бичигт ангийн үйл ажиллагааны онцлог /*тухайлбал: оёдлын үйлдвэр, үйлдвэрийн дамжлага хоорондын үйл ажиллагаа, хэвлэх цех, Аварга тосон сувилал, цайны газар, газар тариалан, мал аж ахуй*/-той холбоотой анхан шатны баримт, бүртгэл, тайлан тооцооны талаар тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

- 3.4.2 Эрсдэл: Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт алдагдах, холбогдох стандарт, хууль эрхийн акт зөрчигдөх.
- 3.4.3 Өгсөн зөвлөмж: НБББББ-ийг шинэчлэх буюу ангийн үйлдвэр, цех, салбаруудын үйл ажиллагааны онцлогт тохирсон анхан шатны баримт маягтуудыг тушаалаар батлан, бүртгэл, тайлан тооцооны талаар нэмэлт журам заавар боловсруулж батлан мөрдөж ажиллах.
- 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,497,865,632.00	1,436,976,048.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	197,276,964.30	13,733,834.36
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	4,188,503.81	6,569,987.64
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	193,088,460.49	7,163,846.72
3121	Төгрөг	193,088,460.49	7,163,846.72
31213	Арилжааны банк дахь харилцах	193,088,460.49	7,163,846.72
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	332,973,809.00	360,680,007.66
33401	Дансны авлага /ТӨҮГ/	332,910,743.12	360,599,331.72
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	63,065.88	80,675.94
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	967,614,858.70	1,062,562,206.02
351	Түүхий эд материал	672,039,777.08	561,785,828.29
35110	Тусгай зориулалттай материал	672,039,777.08	561,785,828.29
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		46,423,064.87
35300	Бэлэн бүтээгдэхүүн	75,012,440.35	283,119,678.29
354	Хангамжийн материал	183,012,641.27	136,573,634.57
35420	Аж ахуйн материал	177,570,310.43	132,733,570.59
35430	Сэлбэг хэрэгсэл	5,442,330.84	3,840,063.98
35600	Мал амьтад	37,550,000.00	34,660,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,766,122,797.03	1,730,951,596.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,766,122,797.03	1,730,951,596.03
391	Газар		
392	Биет хөрөнгө	1,640,055,270.61	1,599,968,236.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,455,496,627.25	1,479,697,036.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	2,498,279.63	112,642,522.49
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,913,249.99	58,911,939.99
39204	Хуримтлагдсан элэгдэл	48,178,964.63	27,186,863.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	293,756,230.78	259,245,560.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	150,094,613.68	115,803,230.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,595,726.55	49,858,477.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	45,895,788.82	11,215,943.51
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,083,343.27	34,893,347.82
39215	Хуримтлагдсан элэгдэл	15,122,260.47	15,789,565.67
393	Биет бус хөрөнгө	126,067,526.42	130,983,359.35
39301	Програм хангамж	127,834,000.00	132,884,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	1,766,473.58	1,900,640.65
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,263,988,429.03	3,167,927,644.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	269,196,313.13	110,771,132.96
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	269,196,313.13	110,771,132.96
412	Богино хугацаат зээлийн өглөг	-	60,000,000.00
4121	Төгрөг	-	60,000,000.00
41217	Санхүүгийн бусад байгууллага		60,000,000.00
413	Өглөг	108,036,419.13	50,771,132.96
4136	Бусад өглөг	108,036,419.13	50,771,132.96
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	83,452,413.97	49,204,498.92
414	Урьдчилж орсон орлого	161,159,894.00	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	161,159,894.00	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,994,792,115.90	3,057,156,511.11
51	Засгийн газрын хувь оролцоо	2,994,792,115.90	3,057,156,511.11

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,485,302,623.27	1,485,302,623.27
51101	Өмч: - төрийн	1,485,302,623.27	1,485,302,623.27
512	Хуримтлагдсан үр дүн	733,552,344.77	734,246,689.74
51210	Өмнөх үеийн үр дүн	387,876,394.44	733,552,344.77
51220	Тайлант үеийн үр дүн	345,675,950.33	694,344.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	775,937,147.86	837,607,198.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,263,988,429.03</u>	<u>3,167,927,644.07</u>

4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
120010	Борлуулалтын орлого (цэвэр)	5,822,344,508.78	5,389,639,876.82
120011	Борлуулалтын өртөг	4,858,399,659.39	4,630,572,511.12
	Нийт ашиг (алдагдал)	963,944,849.39	759,067,365.70
120005	Түрээсийн орлого	-	-
120002	Хүүний орлого	10,190,380.07	7,910,084.92
120001	Ногдол ашгийн орлого	-	-
	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
120009	Бусад орлого	76,120,163.35	19,780,621.23
210810	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
210811	Ерөнхий ба удирдлагын зардал	559,997,909.64	607,012,529.96
210812	Санхүүгийн зардал	14,042,272.73	2,620,000.00
210813	Бусад зардал	23,825,053.48	25,646,530.67
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	-	72,454.25
225001	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,305,767.70	150,679,971.06
	Бусад ашиг (алдагдал)	-	-
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	384,084,389.26	771,494.41
	Орлогын татварын зардал	38,408,438.93	77,149.44
	Татварын дараах ашиг (алдагдал)	345,675,950.33	694,344.97
	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	345,675,950.33	694,344.97
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
145001	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
	Орлогын нийт дүн	345,675,950.33	694,344.97
	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1	Мөнгөн орлогын дүн (+)	6,861,224,439.81	6,500,135,113.42
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,830,161,108.08	6,492,457,541.97
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	7,344,031.00	-
120009	Бусад мөнгөн орлого	23,719,300.73	7,677,571.45
2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,989,934,194.92	6,748,968,328.28
210106	Ажиллагчдад олгосон мөнгө	803,765,353.00	823,284,422.41
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	164,325,851.69	192,794,421.80
210410	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	5,016,803,187.21	4,605,367,434.45
210305	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	489,096,218.59	453,532,210.96
210402	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	2,083,790.00	11,158,400.00
210815	Хүүний төлбөрт төлсөн	11,309,760.00	-
210816	Татварын байгууллагад төлсөн	159,535,795.08	363,717,115.56
210817	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	1,335,360.00	1,121,052.00
210818	Бусад мөнгөн зарлага	341,678,879.34	297,993,271.10
3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(128,709,755.11)	(248,833,214.86)
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Мөнгөн орлогын дүн (+)	10,190,380.07	7,910,084.92
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
140007	Хүлээн авсан хүүний орлого	10,190,380.07	7,910,084.92
	Мөнгөн зарлагын дүн (-)	-	2,620,000.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	-	2,620,000.00
4	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,190,380.07	5,290,084.92
	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
5	Мөнгөн орлогын дүн (+)	239,100,000.00	60,000,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	239,100,000.00	60,000,000.00
	Бусад орлого	-	-
6	Мөнгөн зарлагын дүн (-)	261,442,272.73	-
230001	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	247,400,000.00	-
250002	Бусад зарлага	14,042,272.73	-
7	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(22,342,272.73)	-
8	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(140,861,647.77)	(183,543,129.94)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	338,138,612.07	197,276,964.30
10	Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	197,276,964.30	13,733,834.36

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,302,623.27	775,937,147.86	733,552,344.77	2,994,792,115.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,485,302,623.27	775,937,147.86	733,552,344.77	2,994,792,115.90
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,302,623.27	775,937,147.86	733,552,344.77	2,994,792,115.90
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,302,623.27	775,937,147.86	733,552,344.77	2,994,792,115.90
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,485,302,623.27	775,937,147.86	733,552,344.77	2,994,792,115.90
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		61,670,050.24		61,670,050.24
Тайлант үеийн үр дүн			694,344.97	694,344.97
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,302,623.27	837,607,198.10	734,246,689.74	3,057,156,511.11

4.5. Зорилтот түвшин түүний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Борлуулалтын орлого (цэвэр)	4,893,923,954.00	5,389,639,876.82	495,715,922.82	110.1
Борлуулалтын өртөг	4,252,791,053.00	4,630,572,511.12	377,781,458.12	108.9
Нийт ашиг (алдагдал)	641,132,901.00	759,067,365.70	117,934,464.70	118.4
Түрээсийн орлого			-	
Хүүний орлого		7,910,084.92	7,910,084.92	
Бусад орлого		19,780,621.23	19,780,621.23	
Борлуулалт, маркетингийн зардал			-	
Ерөнхий ба удирдлагын зардал	415,161,660.00	607,012,529.96	191,850,869.96	146.2
Санхүүгийн зардал		2,620,000.00	2,620,000.00	
Бусад зардал		25,646,530.67	25,646,530.67	
Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз		72,454.25	72,454.25	
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		150,679,971.06	150,679,971.06	
Бусад ашиг (алдагдал)			-	
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	225,971,241.00	771,494.41	(225,199,746.59)	0.3
Орлогын татварын зардал	22,597,124.00	77,149.44	(22,519,974.56)	0.3
Татварын дараах ашиг (алдагдал)	203,374,117.00	694,344.97	(202,679,772.53)	0.3
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	203,374,117.00	694,344.97	(202,679,772.53)	0.3
Бусад дэлгэрэнгүй орлого			-	
Бусад олз (гарз)			-	
Орлогын нийт дүн	203,374,117.00	694,344.97	(202,679,772.53)	0.3
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-	-	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020.03.13			САГ-2020-/56/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“” “Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус анги 2019 онд кассаас 11,035.3 мянган төгрөгийг бэлэн мөнгөөр шатахууны зардалд олгож, “Магнай трейд” ХХК-аас худалдан авсан 22,500.0 мянган төгрөгийн шатахууны талоныг кассаар дамжуулан зарцуулсан боловч кассын гүйлгээний журналд талоны зарцуулалтыг тусад нь бүртгэж тайлагнаагүйгээс шатахууны зардалд тухай бүр таланоор эсвэл мөнгөөр олгож байгааг тооцох боломжгүй болсон байна.	22.5	Зөвлөмж	“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын захирагч, хурандаа Санхүүгийн тасгийн дарга, дэд хурандаа	Б.Батбаяр Б.Жаргалсайхан
2	Тус ангийн автомашины шатахуун зарцуулалтын тооцоог шалгаж үзэхэд Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Жолоочийн тооцооны хуудас НХМаягт Т-4 маягыг хөтлөөгүй, 28,850.7 мянган төгрөгийн шатахууны зарцуулалт, хэтрэлт, хэмнэлтийн тооцоог хийгээгүй, нормоор тооцож шууд зардал болгож тайлагнасан байна.	28.8	Зөвлөмж	“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын захирагч, хурандаа Санхүүгийн тасгийн дарга, дэд хурандаа	Б.Батбаяр Б.Жаргалсайхан
3	Тайлант оны зорилтот түвшний орлого, зардлын төлөвлөгөөнд үндсэн бус үйл ажиллагааны орлого, зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлыг төлөвлөж өгөөгүй, Баянзүрх дүүргийн 72 дугаар хотхоны орон сууцны цахилгаан, ус, дулааны ашиглалтын ажиллагааг мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөхөд комиссоос шаардсан засвар үйлчилгээг хийхэд 155.4 сая төгрөг, ХХЕГ-тай байгуулсан өмнөх оны үр	-	Албан шаардлага	“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын захирагч, хурандаа Санхүүгийн тасгийн дарга, дэд хурандаа	Б.Батбаяр Б.Жаргалсайхан

	дүнгийн гэрээний урамшууллын 39.9 сая төгрөг зэрэг 195,3 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй зардлууд нь тус ангийн үйл ажиллагаанаас шалтгаалахгүйгээр гарч ерөнхий ба удирдлагын зардал хэтрэхэд нөлөөлсөн байна.				
4	Тус анги санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа 2014 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг /НБББББ/-ийг баримтлан ажиллаж байна. Гэвч уг баримт бичигт ангийн үйл ажиллагааны онцлог /оёдлын үйлдвэр, үйлдвэрийн дамжлага хоорондын үйл ажиллагаа, хэвлэх цех, Аварга тосон сувилал, цайны газар, газар тариалан, мал аж ахуй/ -той холбоотой анхан шатны баримт, бүртгэл, тайлан тооцооны талаар орхигдуулсан байна.	-	Зөвлөмж	“Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-ын захирагч, хурандаа Санхүүгийн тасгийн дарга, дэд хурандаа	Б.Батбаяр Б.Жаргалсайхан
	Нийт	51.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 09

№ 02/109

Улаанбаатар хот

СМ- 0000/56/СМ-ТӨСГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хилийн 0288 дугаар анги" ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант оны зорилтот түвшний орлого, зардлын төлөвлөгөөнд үндсэн бус үйл ажиллагааны орлого, зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлыг төлөвлөөгүй. Баянзүрх дүүргийн 72 дугаар хотхоны орон сууцны цахилгаан, ус, дулааны ашиглалтын ажиллагааг мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөхөд комиссоос шаардсан засвар үйлчилгээг хийхэд 155.4 сая төгрөг, ХХЕГ-тай байгуулсан өмнөх оны үр дүнгийн гэрээний урамшууллын 39.9 сая төгрөг төгрөгийн төлөвлөгдөөгүй зардлууд гарч ерөнхий ба удирдлагын зардал хэтэрсэн байна.
2. 2019 оны батлагдсан төлөвлөгөөнөөс борлуулалтын өртөг 377.8 сая төгрөгөөр, ерөнхий ба удирдлагын зардал 191.8 сая төгрөгөөр хэтэрч, улмаар тайлант оны ашгийн төлөвлөгөө 202.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал" батламж мэдэгдэл болон Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д "төсвийн тогтвортой байдлыг хангасан байх", 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалтыг тус тус зөрчиж байна.

"Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээр дурдсан төлөвлөгөөг бодитой төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажиллах
2. Зорилтот түвшнийг ханган албан шаардлагын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Хилийн 0288 дугаар анги" ТӨААТҮГ-ын захирагч, хурандаа Б.Батбаяр, Санхүүгийн тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Жаргалсайхан нарт даалгав.

БИЧСЭН:

САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР *Д.Цэгмиддорж* Д.ЦЭГМИДДОРЖ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:

"БАЯН СУВАРГА АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ *С.Должинсүрэн* С.ДОЛЖИНСҮРЭН
АУДИТОР *Х.Тунгалагтуяа* Х.ТУНГАЛАГТУЯА

АЛБАН ШААРДЛАГА

ЗӨВШӨӨРСӨН:

ХИЛИЙН 0288 ДУГААР АНГИ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАГЧ, ХУРАНДАА *Б.Батбаяр*

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ *Б.Жаргалсайхан*

Б.ЖАРГАЛСАЙХАН

Акт, албан шаардлагын биелэлт хагасдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10\Richie_Kherep\Alban Shaardlaga\2020\0310SAG2.Docx

001080367

